



№11 (150)

2023 оны 11-р сар

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

ЭНЭ ДУГААРТ:

**ЗУУХ №5-8-ЫН ХЯНАЛТ
УДИРДЛАГЫН СИСТЕМ
ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ТУХАЙ**

2-р нүүрт

**2023 ОНЫ 11-Р
САРЫН ТЭЗҮ**

3-р нүүрт

**2023 ОНЫ 11-Р САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

4-р нүүрт

**ЯВЦУУ ДАМЖЛАГА АРИЛГАХ,
САНАЛ САНААЧЛАГААР ХИЙЖ
ИРҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

5-р нүүрт

**КОМПАНИЙН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ 9 ТӨРӨЛТ
ТЭМЦЭЭНИЙ ДҮН**

6-р нүүрт

**СТАНЦЫН АЖИЛТНУУДЫН
ЭСЛЭГИЙН ХЭРЭГЛЭЭ БА
ЦУСАН ДАХЬ ХОЛЕСТРИНЫ
ХАМААРАЛ**

**ДОХ ӨВЧНИЙ ТАЛААРХИ
ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ**

7,8-р нүүрт



Сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2602 дугаарын утас, sxa@tpp4.mn эсвэл СХА-нд файлаар болон бичгээр өгч болно.



www.tpp4.mn/erchim



ARC CUP-2023 ГАГНУУРЧДЫН ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭН

"Arc Cup 2023" олон улсын гагнуурчдын тэмцээн БНХАУ-н Өвөр Монголын Хөх хотод 2023 оны 11-р сарын 18-25-ны өдрүүдэд боллоо.

Тус тэмцээнд БНХАУ, ОХУ, Монгол, Болгар, Энэтхэг, Зааны ясан эрэг, Беларусь зэрэг 7 улсын 57 багын 343 гагнуурчин оролцож өрсөлдлөө. Тэмцээн 25 нас хүртлэх, 35 нас хүртлэх гэсэн 2 насны ангилалаар 5-н төрөлд ур чадвараа сорив.

Тэмцээний дүрмийн дагуу БНХАУ-ын 50 баг хоорондоо өрсөлдөж, гадаадын 6 орны 7 багийн гагнуурчдыг тусад нь дүгнэж байр эзлүүлэв. Олон улсын багуудын ангилалд Монгол улсын баг тэргүүн байр, ОХУ-ын НАКС баг 2-р байр, Оросын гагнуурын нийгэмлэг баг гуравдугаар байрт тус тус шалгарч цом, батламж хүртлээ.

Монгол улсаас 16 гагнуурчин тэмцээнд оролцлоо.

25 хүртлэх насны ангилалд:


- "Оюутолгой" компанийн Ж.Жанлав-Ойдов хагас автомат болон хийц бэлэн бүтээгдэхүүн гэсэн 2 төрөлд алтан медаль;
- "MCS Property" компанийн Т.Оюун-Эрдэнэ аргон гагнуурын төрөлд алт;
- Герман-Монголын МСҮТ-ийн М.Сүхбат цахилгаан гагнуурын төрөлд алт;

35 хүртэлх насны ангилалд:

- "Хасу Мегаватт" компанийн С.Баасанхүү аргон гагнуурын төрлөөр алт;
- "MCS Property" компанийн Х.Бямбажав цахилгаан гагнуурын төрлөөр мөнгө;
- "ДЦС-4" ТӨХК-ийн Э.Батсүх цахилгаан гагнуурын төрлөөр хүрэл;
- "Оюутолгой" компанийн Б.Занданбат хагас автомат гагнуурын төрлөөр хүрэл медаль тус тус хүртлээ.

Монгол улсын баг 5 алт, 1 мөнгө, 2 хүрэл нийт 8 медаль хүртсэн амжилтаар багийн дүнгээр түрүүлж гагнуурын ур чадвараа олон улсад таниулж амжилттай оролцлоо.

Тус тэмцээнд "ДЦС-4" ТӨХК-ийн зүгээс дараах багийн бүрэлдэхүүнтэй оролцлоо. Үүнд:



- Ө.Үйтүмэн /СХА, гагнуурын багш техникч, багийн удирдагч, дасгалжуулагч/
- Э.Батсүх /ЗЦ, цахилгаан, гар нуман гагнуур/
- Б.Оргил /ЗЦ, цахилгаан, гар нуман гагнуур/
- С.Мөнх-Эрдэнэ /ТЦ, цахилгаан, гар нуман гагнуур/

Олон улсын гагнуурчдын тэмцээнээс гагнуурын техник технологи, олон улсын гагнуурчдын ур чадвар, гагнуурын орчин үеийн тоног төхөөрмжүүдтэй танилцаж туршлага хуримтлуулан ирлээ.

Тус тэмцээний бэлтгэл хийх болон зардлыг шийдэж, бүх талаар дэмжин ажилласан компанийнхаа хамт олонд талархал илэрхийлье.

ЗУУХ №5-8-ЫН ХЯНАЛТ УДИРДЛАГЫН СИСТЕМ ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ТУХАЙ




Станцын зуухны хяналт удирдлагын систем DCS нь 15-20 жил ажиллаж байна. Урт хугацаанд ашиглагдаж буй системийн стандарт арилжааны борлуулалт аль хэдийн дууссан бөгөөд зарим техник хангамжийн нийлүүлэлт зогссон төдийгүй засвар үйлчилгээний боломжит дэмжлэг хумигдах болсон билээ. Эдгээр шалтгааны улмаас хуучирч муудсан, гүйцэтгэл хязгаарлагдмал болсон зэргийн улмаас станцын хэвийн найдвартай ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүйгээс гадна үйлдвэрлэлийн алдагдал болон засвар үйлчилгээний өртөг нэмэгдэх зэрэг санхүүгийн болон худалдан авалтын эрсдэл гарах магадлалтай байна. Эдгээр эрсдэлт хүчин зүйлсийг арилгах зорилгоор "ДЦС4" ТӨХК болон Ёкогава Электрик Кореа компани хооронд Зуух №5-8-ын хяналт удирдлагын систем шинэчлэх төсөл хэрэгжүүлэх гэрээг 2023 оны 8-р сарын 9-нд байгуулсан бөгөөд 2024 оны зуухны засварын хугацаанд бүрэн хэрэгжүүлж дуусгана.

Ёкогава Электрик Кореа компани нь шинэчлэлийн ажлын зураг төсөл хийх, DCS-ийн шинэ программ хангамж болон шинэ техник хангамж, сүлжээний панель, тэжээлийн блок, оролт гаралт модуль гэх мэтийг үйлдвэрлэж нийлүүлэх, тэжээлийн болон сүлжээний кабель, холбох хэрэгсэл нийлүүлэх,


программ болон техникийн хангамж туршиж тохируулах, зүгшрүүлэх ажлыг хариуцна.

"ДЦС-4" ТӨХК нь нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж угсрах, кабель шугамын угсралтын ажлыг хариуцна.

2023 оны 11-р сарын 21~23-нд станц дээр төслийн ээлжит уулзалт болж, нийлүүлэх техник хангамжийн үзүүлэлтийг эцсийн байдлаар тохирсон бөгөөд худалдан авалт, үйлдвэрлэл явагдаж байгаа талаар мэдээлэл хийжээ.



Зураг 1. Системийн конфигурац – Одоо байгаа



Зураг 2. Системийн конфигурац (Зуух №5,6,7,8) – Төсөл дууссаны дараа

СХА-ны Төсөл судалгааны инженер - орчуулагч
Х.Амгаланбаатар

CNC ТОКАРИЙН “МОНГОЛ УР ЧАДВАР”-ЫН 3-Р ШАТНЫ ТЭМЦЭЭН

CNC токарийн “Монгол ур чадвар”-ын 3-р шатны тэмцээн 2023 оны 12-р сарын 11-ны өдөр Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн Засвар, Механикийн завод дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Уг тэмцээнд Барилгын политехник коллеж, Налайхын политехник коллежийн хүүхдүүд төгсгөлийн шатанд өрсөлдөн аваргаа тодруулав. “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв”-ийн 5 сургуулийн 20 орчим суралцагч хүүхдүүд өрсөлдсөнөөс

“Барилгын политехник коллеж”-ийн оюутан А.Нямбаяр Монгол улсын үндэсний аваргаар шалгарч, 2024 онд Францын Парис хотноо зохион байгуулагдах Дэлхийн ур чадварын “World skills CNC3” төрөлд Монгол улсаа төлөөлөн өрсөлдөх эрхээ авлаа. Тэмцээнийг Эрдэнэт үйлдвэр, МБИХ, ШУТИС, ЧПМ зэрэг байгууллагууд хамран зохион байгуулсан.

2023 оны CNC токарь төрлийн улсын аврага /А.Нямбаяр/ “World skills CNC” төрөлд манай улс 2016 оноос хойш 4 удаа оролцсон бөгөөд Дэлхийд тэргүүлэгч 20 орны операторуудын босго 700 оноог биелүүлэх зорилго тавиад байгаа юм. Энэхүү тэмцээний зохион байгуулалтын бүрэлдхүүнд “Металл боловсруулалт Инженерчлэлийн холбоо”-ны удирдах зөвлөлийн гишүүн СХА-ны ЗБТСХ-ийн менежер Д.Тулга, хяналтын хэмжилтийн багт зургийн техникч Д.Билгүүн нар оролцон ажиллалаа.



2023 ОНЫ 11-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавараас **5128,289** мян.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, **777,116** мян.кВтц-аар зөрчиж, төлөвлөгөөг **4351,173** мян.кВтц-аар давуулан биелүүлсэн. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал **540МВт**, дээд ачаалал **754 МВт** байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт,%
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	417.1	421.4	+4.3	101.0%
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	533.3	533.3	-	100.0%

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - **101,0%**, ДЭХ - **100,0%** биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт	Диспетчерийн графикийн нэмэх зөрчил
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц	мян.кВтц
73	5128.289	17	743.165	6	777.116	754	540	4351.173	-

СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд **157,313** мян.кВтц буюу **15,4** сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, СПОТ зах зээлээс **45,617** мян.кВтц буюу **0,8** сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж авсан. Авлага өглөгийн зөрүүгээр **14,6** сая.төгрөгийн ашигтай ажилласан. Өссөн дүнгээр манай станц **160,0** сая.төгрөгийн авлагатай.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс **37,9** сая.кВтц-аар давуулан **109,9** %-н биелэлттэй, оны эхнээс **189,2** сая.кВтц-аар давуулж, **105,2%** -ийн биелэлттэй байна. Цахилгаан эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 11-р сартай харьцуулбал **19,2** сая.кВтц буюу **4,8%**-н өсөлттэй байлаа.

Дулааны эрчим хүчний түгээлт **7,4** мян.Гкал-аар давуулан **101,4%**-н биелэлттэй, харин оны эхнээс нийт дулааны төлөвлөгөө **17,7** мян.Гкал-аар, УБДСХК -д нийлүүлэх дулаан **54,5** мян.Гкал-аар тасарч байна. Дулааны эрчим хүчний түгээлт өнгөрсөн оны мөн үеэс **37,2** мян.Гкал-аар буюу **7,5%** өссөн.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд **8** зуух, **6** турбин оролцсон. Сарын дунджаар **7,11** зуух, **6,7** турбинтэй ажиллаж, бэлтгэлд зуух, турбингүй ажилласан.

Мазутын зарцуулалт

Энэ сард **120** тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс **115** тн-г түлж, **5** тн мазут хэмнэсэн.

Тайлант хугацаанд **4** удаагийн хүйтэн галлагаанд **81** тн мазут, **5** удаагийн халуун галлагаанд **34** тонн мазут түлсэн. Нэг хүйтэн галлагаанд дунджаар **20** тн мазут зарцуулсан байна.

Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	210.000	190.488	-19.512	90.7%
Шивээ-Овоо	мян.тн	180.000	189.398	9.398	105.2%
Бүгд	мян.тн	390.000	379.886	-10.114	97.4%

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш **1.085** гр/кВтц-аар хэтэрч, дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш **0.219** кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс **574** тн жишмэл түлш буюу **1217** тонн бодит түлш /илчлэг **3302** ккал/кг/ хэтэрсэн.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ-аас батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг **0,62%**-аар буюу **2917,616** мян.кВтц-аар хэмнэж ажилласан.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	11-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/ тн.нүүрс	30.97	29.31
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/ тн.уур	4.55	4.31
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.тэж ус	7.79	7.37
4	Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан	%	1.04	0.98
5	Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан	кВтц/Гкал	0.66	0.62

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг төлөвлөсөн хэмжээнээс **0,68%**-аар бууруулж **14782** тонн хэмнэж ажилласан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт **7891** тн-оор буурсан байна.

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Зууханд: **296** м³ ус өгсөн.
- БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт - **19488** м³ байлаа.

Осмосын халаагч уурын зарцуулалт **4167** тн байлаа.



2023 ОНЫ 11-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2023 оны 11-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 9 бүртгэгдсэнээс зуух 8 удаа, турбин 1 удаа зогссон.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2022 оны 11-р сар	2023 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2023 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2023 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2023 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2023 оны 11-р сар
1	Зуух	2	3	1	2	-	-	7	3	10	8
2	Турбин	-	-	-	1	-	-	1	-	1	1
Дүн		2	3	1	3	-	-	8	3	11	9

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: ЦЦ-1 (168,500 ₮), ТЦ-1 (101,775 ₮) **Бүгд-2 (270,275 ₮)**
 - Мазут зарцуулалтын акт: ЗЦ-3 (87,045,879 ₮), ДХХАЦ-1 (8,625,333 ₮), ТЦ-1 (16,653,331 ₮), ЦЦ-1 (11,085,802 ₮) **Бүгд-5 (123,410,345 ₮)**
 - Тоног төхөөрөмж, сэлбэг материал ашиглалтаас хасах акт: ЦЦ-3 (0 ₮), СХА-1 (0 ₮), **Бүгд-2 (0 ₮)**
- Нийт 16 ширхэг (123,680,620 төгрөг) акт тогтоогдсон.**

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (Нэг удаагийн)

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (85 дБ)		Ажлын байрны халуун (12-30 °C)		Ажлын байрны чийглэг (30-60 %)		Ажлын байрны тоосролт (10 мг/м³)		Тайлбар
		2022 оны 11-р сар	2023 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2023 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2023 оны 11-р сар	2022 оны 11-р сар	2023 оны 11-р сар	
1	ТДЦ	86.2	83.2	15.1	8.8	45.3	45.2	14.45	14.92	
2	ЗЦ	79.8	82.8	25.0	26.6	25.1	22.6	9.8	8.05	
3	ТЦ	77.6	82.2	24.7	25	29.3	30.5	12,13	11,4	Станцын дундаж тоосролт
4	ЦЦ	-	54.3	-	23.4	-	20.1			
5	ХЦ	71.6	73.8	22.2	21.3	31.9	29			
6	МЦ	64.7	74.1	21.5	20.1	21.3	20.8			

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

1. Хяналтын чиглэлээр

№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	80 нарыдад давхардсан тоогоор сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	38 ажлын байранд эргэлт шалгалтын маршрутын дагуу хяналт тавьсан.
3	Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал	100%	Засварт хийгдсэн Зуух №2,5 ажилд хяналт тавьсан.

2. Сургалт, зааварчилгаа

№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	141 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	100%	10 ажилтанд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	3 ажилтнаас шалгалт авсан.
4	Бусад сургалтын талаар	100%	Зэрэг ахих 15 ажилтнаас шалгалт авсан.

3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар

№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	МХЕГ ХАБУЛ-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих	100%	XI/9 ундны цс 3 цэгээс, агаар 2 цэгээс, арчдас 10 ш, хоолны илчлэг 5 төрөл / нян, хими/ нийт 10 порц хоол шинжилгээнд өгсөн. Хариу хэвийн үзүүлэлттэй гарсан.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх	100%	Үндсэн 6 цехд хөдөлмөрийн нөхцлийн болон (4-р улирлын) гэрэлтүүлэгийн хэмжилт үндсэн 6 цехд, хийгдсэн. Мөн ЭЗЦГ-т улирлын хэмжилтүүд тус тус хийсэн.
3	Ундны усны шүүлтүүр солих ажилд хяналт тавьсан талаар	100%	Стандарт ХХК ундны усны цэгүүдийн гэмтлийг устгасан тухай тайлан ирүүлсэн. Хяналт тавьж байгаа
4	Тоосролтын хэмжилтэнд хяналт хийсэн байдал	100%	Нийт 4 удаа хэмжилт хийгдсэн.

4. Бусад ажлын талаар

- ТА №6 түр шийдвэртэй холбоотой аюулгүй байдлыг хангах талаар зааварчилгаа боловсруулж цех, нэгжүүдэд тарааж зааварчилгаа өгсөн.
- Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний ХЯНАЛТЫН ТАЙЛАН хүлээн авч ЕИ, холбогдох нэгжүүдийн дарга, ХАБИ болон ажилтан нарын төлөөлөл байлцуулж хурал зохион байгуулсан.
- Цоож пайзны журам, аюулгүй ажиллагааны эрхийн үнэмлэхний заавар шинээр боловсруулж батлуулж, тушаал гаргуулсан.
- ТЦ-д гарсан осолтой холбоотой холбогдох цехийн инженер, мастер, ажил удирдагч, ажил гүйцэтгэгч нартай уулзалт хийсэн. ТЦ, ЗЦ дээр гарсан аюултай тохиолдлуудад сэрэмжлүүлэх мэдээлэл, даалгавар гаргаж тараалт хийсэн.

ЦЕХ НЭГЖҮҮДЭЭС ЯВЦУУ ДАМЖЛАГА АРИЛГАХ, САНАЛ САНААЧЛАГААР ХИЙЖ ИРҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Бүтэн жилийн хугацаанд цех нэгжүүдээс уламжлал болгон шинэ бүтээл гаргах, ашигтай санал дэвшүүлэх, явцуу дамжлага арилгах чиглэлд санал санаачлагаар хийж гүйцэтгэсэн ажлын тайланг сар бүр бэлдэж СХА-нд ирүүлдэг. Энэ нь эрсдэлтэй ажлын байрны тоог цөөрүүлэх, ХАБ-ыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх олон талын ач холбогдолтой ажил байдаг.

Эрсдэл бууруулж явцуу шат дамжлага арилгах чиглэлээр, санаачилга гарган ажилласан цех хамт олны ажлыг сүүлийн 5 жилээр нэгтгэн гаргалаа.

№	Санал санаачлагаар хийсэн ажлын нэр	Харъяа нэгж
1	Суман шилжүүлгийн шор цоолох суурин цахилгаан өрөм хийх	ТДЦ /14/
2	Цахилгаан түлхэгч-А,Б-д SEL-849 хамгаалалтын блок шинээр суурилуулан, монтажилж ажилд оруулав.	
3	Туузан жин "А"-г шинэчлэх.	
4	Зам төмөр хэлхээний хайрцагны 2А-ын гал хамгаалагчийг, автоматаар сольж суурилуулах.	
5	Туузан дамжуулагчийн нүүрс буулгах хутга ПС-г сайжруулах,засварын ажлыг хөнгөвчлөх	
6	Тусгаарлагч хормойтой хавчиарыг хормойгүй хавчиар болгох	
7	Түлш дамжуулах цехийн хуваарилах байгууламжийн схемд өөрчлөлт оруулах	
8	Туузан дамжуулагч ЛК-4Б-н татах станцын тэргэнцэрийг шинээр хийж солих	
9	Туузан дамжлага ЛК-4А,Б-н МС-н өмнөх нүүрс ярагчид хашлага ремень хийх	
10	ЛК-3а,б-ийн булд механик сорьц авагч хийх	
11	Алхан бутлагчийн плитаг шинээр хийх	
12	PR-736XL G8 бульдозерын хөдөлгүүрийн агаар шүүгчийн ашиглалтын хугацааг уртасгах	
13	Лантууны машин сэргээн засварласан.	
14	Хаягдлын усны насос НГУ-12,13 ийн худаг ухах вакум насос	
1	Туузан зүлгүүрийн машин	ЗЦ /13/
2	Туршилтын стенд /Цахилгаан тоноглол болон багаж хэрэгслийг турших шалгах/	
3	Лист өргөх зөөх хавчаар	
4	SM-19тээрмийн утааны люк шинээр хийх. //Mill-2с/	
5	Тоосон системийн өрөөнд Алдрын булан болон хувцасны өлгүүр шинээр хийх	
6	Тээрмийн рядаар галын хайрцаг шинээр байрлуулах	
7	Цоож, пайз хадгалах сав шинээр хийх	
8	Зуух №3-ын агаарын салхилуурын I II холхивчинд зориулж Масло станц хийсэн.	
9	Суурин засварын талбайн сайжруулалт	
10	Уур халаагчийн IV үеийн гэмтлийн шалтгаан тэдгээрийг бууруулах, бүртгэх, ажилласан цагт хяналт тавих	
11	SM-19 тээрмийн таазны хуяг	
12	Бамбарын шкаф	
13	Мазут аж ахуйн хөөсний станцын өнгө үзэмж сайжруулах	

Энэ онд хийсэн ажлын тоо нийт 76 бүртгэгдсэн байгаа нь сүүлийн 5 жилийн байдлаар харьцуулж үзвэл нэгжүүд ХАБ-ыг сайжруулах, явцуу шат дамжлага арилгах чиглэлээр санаачлагатай сайн ажиллаж байгаа нэг үзүүлэлт болж байна.

	ТДЦ	ЗЦ	ТЦ	ЦЦ	ДХХАЦ	ХЦ	МЦ	ЗА	Нийт тоо
2019 он	11	7	6	2	6	11	7	-	50
2020 он	11	4	12	2	4	9	7	-	49
2021 он	6	3	1	0	1	6	13	-	30
2022 он	7	2	-	-	3	6	51	-	69
2023 он	14	13	10	7	4	12	13	3	76

1	ОГ-35 маркийн конденсат хөргөгчийн шинэчлэлийн ажил	ТЦ /10/
2	ПБ-2, 4, 8-ын корпусын усан талын дээд разьёмыг засварлах	
3	ТА-5,7-ийн ЦФ-ыг 0 тэмдэгтээс 4-р тэмдэгт рүү шилжүүлэх	
4	Турбины урсгал хэсгийн төвлөрүүлэлт хийхэд ашигладаг борштангуудыг байрлуулах тавцанг засах	
5	ПЭН-8-н графикт их засварыг хуучин сэлбэг материал ашиглан сэргээн засварласан	
6	ТА-1-7-н ПВД-н корпус өргөх төхөөрөмж (траверс)	
7	ТА-№6-ын ЦВД, ЦСД-ын сервомоторуудын цилиндрийн дээд крышгийн нягтруулгын хийцийг өөрчлөх	
8	ТА-6-н их засвараар эксгаустер-6А,Б-н ажлын дугуй шинээр хийсэн	
9	ТА 1-6-ийн сервомоторын нягтруулга	
10	ОГ-2 шинэчлэлийн ажил	
1	Шийдвэр, наряд өгөх урсгалыг "Цахим" хэлбэрт шилжүүлэх	ЦЦ /7/
2	Цахилгаан шүүлтүүрийн 0,4кВ-н 1Э-8Э секцийн бэлтгэл трансформаторуудыг (1ТРЭ,2ТРЭ) оновчтой горимоор ажиллуулах тухай	
3	6кВ-н КРУ-26 ячейкны дээд-3, доод-3 ламель шинээр хийсэн	
4	GPS-ийн цагны системийн шугамын алдагдлаас үүсэх 2-догч цагуудын хоцролтыг тэглэх схем.	
5	0.4кВ-ын секцүүдийг засварт гаргаж ажлын байр бэлтгэх, аюулгүй ажиллагаа, ААД-ийн хэрэгжилтийг хангах Зөөврийн газардуулга (6 ширхэг).	
6	Бүх төрлийн эд ангийн голд суусан холхивч, муфт, сэнс сугалагч	
7	ЦШ-ийн тэжээлийн агергатууд болох АТПОМ-уудыг ДТУЦ-1,2-оос алсын удирдлагаар залгаж таслах горим болон цахилнагаан параметруудыг хянах	
1	Зарцуулалтын хэт авианы датчикны чиг баригч / лазер/.	ДХХАЦ /4/
2	Усны хатуулаг тодорхойлох давслагийн хэмжүүрийн стенд.	
3	Эрчим дартсын клубын тохижилт.	
4	Зуух №1-8-ын цахилгаан хаалтны тэжээлийн болон удирдлагын сборкуудад ус зайлуулах усны хаалт хийх.	

1	Вакумын деэраторын хүчилтөрөгчийн шинжилгээний тавцан	ХЦ /12/
2	Баянголын сорьцын цэгт хүчилтөрөгчийн шмнжилгээний тавцан хийж хаягжуулсан.	
3	Крепкий гидразины мешалканд хутгагч хийх.	
4	Лабораторийн агаар сэлгэлт сайжруулах.	
5	Гагнуурын цэгийн өргөтгөл хийх.	
6	Гагнуурын зөөврийн балластик хийх	
7	Уур усны сорьц зөөх сав.	
8	Хуучин элсэн цэвэрлэгээний аппарат засварлаж ажилд оруулах.	
9	Тоноглолд хими хамгаалалт хийх будгийн аппаратыг ашиглах заавар.	
10	Агаарын компрессор №4,7 түвшний шил найдваржуулах.	
11	Агаарын компрессорын үлээлгийн тос хуримтлагдах хайрцаг.	
12	Хими хамгаалалтын хувцас хэрэглэлд цэвэр агаар өгөх.	
1	Агаарын компрессорын заалны агааржуулалтын жалюзыг хүйтэн агаар орохоос урьдчилан сэргийлж, рамтай хаалт хийж битүүлэв.	МЦ /13/
2	Хүчилтөрөгчийн тоноглолын заалны 30 м ² ханыг хусаж цэвэрлэж, будав.	
3	Шатны хомут кранаар зөөх зориулалтын хайрцаг хийсэн.	

4	2-догч материал ашиглан авирдаг шат 25 ш-г хийж, будаж өнгө үзэмж сайжруулав.	МЦ /13/
5	Агуулах №6-г тохижуулж тавцан хийж будав.	
6	Зуухны 21-р тэмдэгтэд шатны материал кранаар зөөх зориулалтын хаалт хашилт бүхий тавцан шинээр хийж эрсдэлээс сэргийлэв.	
7	МОН-ПИ 10 компрессорын хаалтнуудад маховик хийх.	
8	Расточный суурь машин дээр том овор хэмжээтэй эд ангийг босоо байрлалд зорох технологийн хэрэгсэн шинээр хийх	
9	Крануудын 4 салаа дэгээнд түгжээ хийх	
9	Цехдээ асар майхан санаачилж хийх	
	Угсармал шатны башмак хийсэн.	
9	Азотын ресивр №1-6-н хуучирсан нийт 12 ш хаалтнуудын хаягийг шинэчлэв	
10	Механик цехийн үйлдвэрлэлийн хэсгийн зааланд 10ш хогийн хутгуур хийх.	
11	Холхивч сугалах гидро съёмник хийв	
12	Цул гуулийг хөндийлж нүхэлж зорох хутга хийв.	
13	ТА коллектор зорох тусгай хутга хийв.	
1	Уур халаагчийн 4-р үеийн пакет хийхэд зориулагдсан хөл, тавцан шинээр хийх	ЗА /3/
2	Цахилгаан тельферт үзлэг үйлчилгээ хийх шат, тавцанд хамгаалалтын хашлага хийх	
3	Дүүжин тулгуурын сургалтын макет	

СХА-ны Патентийн мэргэжилтэн Ч.Баясгалан



КОМПАНИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ 9 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ ДҮН

"ДЦС-4" ТӨХК үүсэн байгуулагдсаны 40 жилийн ойн нэрэмжит "Компанийн аварга спортын хамт олон" шалгаруулах 9 төрөлт тэмцээний сүүлчийн болох снукер билльярдын тэмцээн амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Снукер билльярдын тэмцээн 12-р сарын 01-нд M-TIME клубт бүтэн өдрийн турш явагдаж шилдгүүдээ тодрууллаа. Тэмцээнд нийт 30 багийн 60 гаруй тамирчид өрсөлдөж, П.Баяр-Эрдэнэ даргатай Түлш дамжуулах

цехийн Б.Анар, Т.Гэрэлтбаатар нар алтан медалийн эзэд болсон бол Ахмадын хорооны С.Жаргалсайхан, Ш.Дорж, Хяналтын албаны Э.Гүржав, А.Нямдорж нар удаах байруудыг эзэлж мөнгө, хүрэл медалийн эзэд болсон.

9 төрөлт тэмцээний нийлбэр дүнг бага онооны системээр дүгнэн гаргахад 24 оноогоор Д.Ганболд даргатай Зуухан цехийн хамт олон 2023 оны "Компанийн аварга спортын хамт олон"-оор шалгарах болзлоо хангав.


№	Нэгжийн нэр	Шатар	100 буудалт даам	Ширээний теннис	Волейбол	Сагсан бөмбөг	Дартс	Олс таталт	Снукер билльярд	Хөлбөмбөг	Нийлбэр дүн	БАЙР
1	Захиргаа алба	2	5	1	8	8	5	4	2	4	39	III
2	Захиргаа хэлтэс	3	8	4	1	4	9	6	3	9	47	V
3	ТДЦ	6	2	6	7	1	3	1	1	2	29	II
4	Зуухан цех	1	1	2	4	5	4	2	4	1	24	I
5	Турбин цех	5	3	9	6	3	6	5	3	3	43	IV
6	Цахилгаан цех	9	4	7	3	2	7	5	5	5	47	V
7	ДХХАЦ	8	6	3	2	9	1	7	4	7	47	V
8	Хими цех	4	9	8	9	6	8	7	6	8	65	VII
9	Механик цех	7	7	5	5	7	2	3	6	6	48	VI



СТАНЦЫН АЖИЛТНУУДЫН ЭСЛЭГИЙН ХЭРЭГЛЭЭ БА ЦУСАН ДАХЬ ХОЛЕСТРИНЫ ХАМААРАЛ

Хүнсний эслэг нь нийлмэл нүүрс ус бөгөөд жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, шош, буурцагт ургамалд агуулагддаг. Эслэг нь цардуулаас өөр бүтэц бүхий нүүрс ус бөгөөд целлюлоз, гемицеллюлоз, пектин, бета глюкозан зэрэг олон төрлийн нэгдлүүдийг агуулж байдаг ба хоол боловсруулах замд эслэг задарч боловсордоггүй ч өөх тос, нүүрсус, уурагтай адил шим тэжээлт нэгдэл юм. Эдгээр нэгдлийн нэг болох бета глюкозан нь эрүүл мэндэд маш олон ач холбогдолтой бөгөөд хүнсэнд түлхүү хэрэглэх нь цусан дахь холестерин хэмжээг бууруулах, зүрх судасны өвчин, цус харвалт, цусны сахар ихсэлт, чихрийн шижин, таргалалт, ходоод гэдэсний эмгэгийн эрсдлийг бууруулдаг тул хүн амын шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээнд оруулсан байдаг.

Энэ оны ажилтнуудын цусны дэлгэрэнгүй шинжилгээгээр компанийн ажилтнуудын 40 гаруй хувь нь цусан дахь холестерин хэмжээ өндөр гарсан байна. Цусан дахь холестерин хэмжээ өндөр байх нь зүрх судасны өвчний тэргүүлэх нэг шалтгаан болдог. Хүнсний эслэг нь цусан дахь холестерин хэмжээг бууруулахад нэн тустай гэсэн клиник судалгаа байдаг учир компанийн ажилтнуудын эслэгийн хэрэглээг судлан авч цусан дахь холестерин хэмжээтэй харьцуулалт хийлээ. Энэхүү харьцуулалтаар холестерин түвшин хэвийн байгаа ажилтнуудын хоногийн эслэгийн хэрэглээ **13.8 гр** (өдрийн зөвлөмж хэмжээнээс 49.9%-иар бага), цусан дахь холестерин түвшин өндөр байгаа ажилтнуудын хоногийн эслэгийн хэрэглээ **8.7 гр** (өдрийн зөвлөмж хэмжээнээс 68.3%-иар бага) байна. Графикаар харуулав.



Монголчуудын эслэгийн хэрэглээтэй холбоотойгоор 2013 онд ШУТИС-иас хүн амын хүнсний бодит хэрэглээний судалгаагаар Монголын насанд хүрсэн хүмүүсийн эслэгийн хэрэглээ дунджаар 7 грамм байсан ба насанд хүрсэн хүн хоногт дунджаар 25-30 граммын эслэг авах зөвлөмж хэмжээ байдаг.

Манай ажилтнуудын хоногийн эслэгийн дундаж хэрэглээ нь **9.9** грамм байгаа нь монгол хүний дундаж хэрэглээнээс **2.9** граммаар их байгаа хэдий ч өдрийн зөвлөмж хэмжээний **33.1 – 33.8%** - ийг авч байна. Иймээс эслэгээр

баялаг хүнсний бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэхийг зөвлөж байна.

Зарим хүнсэнд агуулагдах эслэгийн хэмжээ

№	Хүнсний бүтээгдэхүүн	100 граммд агуулагдах эслэгийн хэмжээ, гр
1	Бор будаа	1.8
2	Цагаан будаа	0.4
3	Гурил дээд	2.7
4	Бүхэл үрийн гурил	10.8
5	Арвай	17.3
6	Хөц будаа	17.3
7	Төрөл бүрийн шош	8
8	Бүхэл үрийн талх	5
9	Бүхэл үрийн гоймон	3.5
10	Овьёос	9.2
11	Төмс	4
Хүнсний ногоо		
11	Бөөрөнхий сонгино	3
12	Ногоон сонгино	1.2
13	Саримс	1.5
14	Салат навч	1.2
15	Цоохор майлз	1.8
16	Улаан лооль	1.5
17	Хүрэн манжин	2.5
18	Яншуй	2.1
19	Бөөрөнхий байцаа	2
20	Шар манжин	1.9
21	Амтат чинжүү	1.9
22	Өргөст хэмх	0.7
23	Дарсан өргөст хэмх	0.8
24	Цагаан гаа	2
25	Мөөг 70гр	1
26	Броккли	2.3
27	Лууван	2.5
28	Юуцай	0.7
29	Гишүүнэ	3.2
Жимс		
30	Алим	1.8
31	банана	1.1
32	Үзэм	4.5
33	Чавга	0.9
34	Киви	2.1
35	Барагшуун	2.01
36	Мандарин	4.4
37	Хасарваань 35 гр	7
38	Чацаргана	3
39	Лийр	4
Самар, үр		
40	Алмонд самар	7.4
41	Газрын самар	6.4
42	Наранцэцгийн үр	6



ДОХ ӨВЧНИЙ ТАЛААРХИ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1988 оны 12 сарын 01–ны өдрөөс эхлэн дэлхий нийтээрээ ХДХВ, ДОХ өвчинтэй тэмцэх өдрийг тэмдэглэж эхэлжээ. Энэ жил тус өдрийг дэлхий нийтээрээ “Олон нийтийн манлайллыг дэмжье” уриан доор зохион байгуулсан. НҮБ–ын ДОХ–ын нэгдсэн хөтөлбөрөөс 2022 оны жилийн эцсийн байдлаар дэлхий дахинаа 1,3 сая хүн шинээр ХДХВ–ийн халдвар авч, 630 мянган хүн ДОХ–ын улмаас нас барсан. 2022 онд хийгдсэн тооцооллоор дэлхий дахинаа нийт 39 сая хүн халдвартай амьдарч байх магадлалтайгаас 86% нь өөрийнхөө оношийг мэддэг бөгөөд тэдний 76% нь эмчилгээ, тусламж үйлчилгээнд хамрагдсан судалгаа гарсан байдаг.

Монгол Улсад ХДХВ–ын халдварын анхны тохиолдол 1992 онд бүртгэгдсэнээс хойш өнөөдрийн байдлаар нийт 367 хүн ХДХВ–ийн халдвартай нь оношлогдож, үүнээс 63 хүн нас барсны 35 нь ДОХ–ын шалтгаантай байна. ХДХВ–ийн халдвартай гэж бүртгэгдсэн тохиолдлын тоогоор манай улс нийт хүн амын дунд бага тархалттай, харин эрсдэлт бүлгийн хүн амын дунд буюу ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай залуусын дунд төвлөрсөн тархалттай орны тоонд багтдаг. Манай улсад бүртгэгдсэн ХДХВ–ийн халдвартай хамгийн удаан хянагдаж буй хүн 26 жилийн турш ретровирусын эсрэг эмчилгээ, тусламж үйлчилгээнд тогтмол хамрагдсанаар урт удаан амьдарсаар байна.

Халдвар дамжих зам:

- Хамгаалалтгүй бэлгийн хавьтал /үрийн шингэн, үтрээний шүүрэл/
- Халдвартай цус, цусан бүтээгдэхүүн, зүү тариур дамжуулан хэрэглэх
- Халдвартай эхээс хүүхдэд – төрөхөөс өмнө, төрөх үед, төрсөний дараа хөхний сүүгээр

ХДХВ–ийн халдвар дараах тохиолдолд дамжихгүй.

- ХДХВ–ийн халдвартай хүнтэй хамт хооллох, хувцас аяга тавгаа дундаа хэрэглэх, тэврэх, үнсэх, гар барих
- Жорлонгийн суултуураар, усан санд ороход, ханиах, найтаахад
- Халдвартай хүнтэй хамт ажиллаж, амьдрахад

Халдвар авсанаас хойш дархлалын тогтолцоо халдварыг эсэргүүцэж эхэлтэл 3 сар өнгөрдөг ба энэ хугацаанд цусны шинжилгээнд өөрчлөлт гарахгүй тул ХДХВ оношлогдохгүй. Энэ үеийг “Цонх үе” гэдэг. Иймээс ямар нэг эрсдэлд орсон бол 3 сарын дараа дахин шинжилгээ өгөх хэрэгтэй.



Илрэх шинж тэмдэг:

ХДХВ нь хүний дархлалын тогтолцоог гэмтээж, дархлааг аажмаар сулруулдаг. Тухайн хүний биеийн эсэргүүцлээс хамааран дархлалын тогтолцоог гэмтээх явц нь хамгийн багадаа 6 сараас бүр цаашлаад 10 гаруй жил үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд тухайн хүнд ямар нэгэн зовиур илрэхгүй, эрүүл хүн шиг байх боловч халдвар тараах эрсдэлтэй. Хүний дархлалын тогтолцоо сулрах тусам тухайн хүн турж эцэн, амархан ядарч сульдаж янз бүрийн өвчинд өртөмтгий болж эхэлдэг.

Урьдчилан сэргийлэлт:

- Хосууд бие биедээ үнэнч байх
- Тохиолдлын бэлгийн хавьтлаас татгалзах, тэвчих
- Бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвчийг зөв, тогтмол хэрэглэх
- Зүү, тариур дамжуулан хэрэглэхгүй байх
- Архи, мансууруулах бодис хэрэглэхээс татгалзах
- ХДХВ–ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаж байх

Манай улсын хувьд ХДХВ/ДОХ–ын эмчилгээ оношлогоо, тусламж үйлчилгээг олон улсын жишиг стандартад нийцүүлэн үзүүлж байна. 2013 оноос ДЭМБ–аас зөвлөмж болгосон ретровирусын эсрэг өндөр идэвхит эмийн хослол бүхий эмчилгээг улсын төсвөөс санхүүжүүлэн хэрэглэж байна.

Ашигласан ном материал: Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ, БЗДХ–ын тандалт судалгааны албаны мэдээлэл

That Might Motivate You № 16

